ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Орхон сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДАА-2022/01-НА-СТА-ОНА

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2022 он | Тэргүүлэх аудиторын албан үүргийг<br>түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**<br>Утас: **7037-3089**<br>Цахим хаяг: m**unkhbayarsh@audit.gov.mn**<br>Ахлах аудитор: **С.Батцэцэг**<br>Утас: **7037-3089**<br>Цахим хаяг: battsetsegs**@audit.gov.mn**<br>Аудитор: Ч.**Цэрэннадмид**<br>Утас: **9511-2689**<br>Цахим хаяг: tsesb.audit**@gmail.com** |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт....................4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.................... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /Төгрөгөөр/.................... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.................... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.................... 8
3.Аудитын тайлан.................... 11
3.1. Ерөнхий зүйл....................11
3.2 Дотоод хяналт....................11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.......... 15
5.1 Шилэн дансны мэдээлэл....................16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.................... 16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.................... 16
8. Аудитын илрүүлэлт.................... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....................20

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.03.15 № 246

танай ______ -ны № ______ -т

"ОРХОН ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Б.МӨНХБАЯР
ТАНАА

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (*Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл*) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР

9022899
5517143826

**Товчилсонүгийнжагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

**Товчилсонүгийнжагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /Төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 30,434.03 | 1,048,677.41 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,556,630.00 | 7,620,637.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | | |
| 1.1.4 | Бусад авлага | 105,638.00 | - |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 34,044,187.48 | 34,809,987.48 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **35,736,889.51** | **43,479,301.89** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,874,548,543.05 | 2,235,316,272.46 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 63,867,249.97 | 63,742,249.93 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,938,415,793.02** | **2,299,058,522.39** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,974,152,682.53** | **2,342,537,824.28** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 39,361.30 | - |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | - | - |
| 2.1.1.3 | Татварын өр | 919,559.61 | 3,139,179.53 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 905,369.33 | 1,681,292.94 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | 120,000.00 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,864,290.24** | **4,940,472.47** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | - | - |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,864,290.24** | **4,940,472.47** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 111,595,600.00 | 111,595,600.00 |
| 2.3.2 | - хувийн | - | - |
| 2.3.3 | - хувьцаат | - | - |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,349,166,957.59 | 1,349,166,957.59 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 472,593,531.00 | 972,145,473.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 38,932,303.70 | (95,310,678.78) |
| 2.3.10 | | | - |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **1,972,288,392.29** | **2,337,597,351.81** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,974,152,682.53** | **2,342,537,824.28** |



ДУГААР 01

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /Төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 30,434.03 | 1,048,677.41 |
| 1.1.2 | Дансны авлага | 1,556,630.00 | 7,620,637.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | | |
| 1.1.4 | Бусад авлага | 105,638.00 | - |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| 1.1.6 | Бараа материал | 34,044,187.48 | 34,809,987.48 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **35,736,889.51** | **43,479,301.89** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 1,874,548,543.05 | 2,235,316,272.46 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 63,867,249.97 | 63,742,249.93 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,938,415,793.02** | **2,299,058,522.39** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,974,152,682.53** | **2,342,537,824.28** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 39,361.30 | - |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | - | - |
| 2.1.1.3 | Татварын өр | 919,559.61 | 3,139,179.53 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 905,369.33 | 1,681,292.94 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | | 120,000.00 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **1,864,290.24** | **4,940,472.47** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | | |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **-** | **-** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,864,290.24** | **4,940,472.47** |
| **2.3** | **Эздийн өмч** | | |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 111,595,600.00 | 111,595,600.00 |
| 2.3.2 | - хувийн | - | - |
| 2.3.3 | - хувьцаат | - | - |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | - | - |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,349,166,957.59 | 1,349,166,957.59 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 472,593,531.00 | 972,145,473.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 38,932,303.70 | (95,310,678.78) |
| 2.3.10 | | | - |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **1,972,288,392.29** | **2,337,597,351.81** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,974,152,682.53** | **2,342,537,824.28** |



ДУГААР 01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **49,970,410.09** | **64,530,358.23** |
| 2 | Борлуулалтын өртөг | 21,661,466.00 | 40,808,965.00 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **28,308,944.09** | **23,721,393.23** |
| 4 | Түрээсийн орлого | | |
| 5 | Хүүний орлого | | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 69,162,700.00 | 83,780,859.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | | |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 210,914,017.33 | 241,590,589.71 |
| 11 | Санхүүгийн зардал | | |
| 12 | Бусад зардал | | |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | **(154,645.00)** |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(113,442,373.24)** | **(134,242,982.48)** |
| 19 | Орлогын татварын зардал | | |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(113,442,373.24)** | **(134,242,982.48)** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(113,442,373.24)** | **(134,242,982.48)** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | - |
| | Бусад олз (гарз) | | |
| **24** | **Орлогын нийт дүн** | | |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | |



ДУГААР 01

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12 сарын 31 | 2021 оны 12 сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **118,980,335.52** | **142,148,203.23** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 49,817,635.52 | 58,367,344.23 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 69,162,700.00 | 83,780,859.00 |
| | Бусад мөнгөн орлого | | |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **117,931,037.83** | **141,129,959.85** |
| | Ажиллагчдад төлсөн | 63,137,474.93 | 69,885,625.14 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 12,997,185.37 | 7,886,954.25 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 14,359,259.00 | 28,379,977.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 15,228,378.20 | 18,282,279.46 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 5,769,250.00 | 10,363,123.00 |
| | Хүүний төлбөрт төлсөн | - | - |
| | Татварын байгууллагад төлсөн | 6,121,107.33 | 6,043,641.00 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 318,383.00 | 288,360.00 |
| | Бусад мөнгөн зарлага | - | |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **1,049,297.69** | **1,018,243.38** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | - | - |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | (1,155,000.00) | - |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,155,000.00)** | - |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 0 | - |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0 | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | - | - |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | - |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | - |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(105,702.31)** | **1,018,243.38** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **136,136.34** | **30,434.03** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **30,434.03** | **1,048,677.41** |



ҮЭСБ-АУДИТ ХХК ДУГААР 01

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 111,595,600.00 | 1,349,166,957.59 | 472,593,531.00 | 152,374,676.94 | 2,085,730,765.53 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | - |
| **3** | **Залруулсан үлдэгдэл** | 111,595,600.00 | 1,349,166,957.59 | 472,593,531.00 | 152,374,676.94 | 2,085,730,765.53 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (113,442,373.24) | (113,442,373.24) |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | | | | | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | - |
| **9** | **2020 оны 01 -р сарын 01 -ний үлдэгдэл** | 111,595,600.00 | 1,349,166,957.59 | 472,593,531.00 | 38,932,303.70 | 1,972,288,392.29 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | - |
| **11** | **Залруулсан үлдэгдэл** | 111,595,600.00 | 1,349,166,957.59 | 472,593,531.00 | 38,932,303.70 | 1,972,288,392.29 |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (134,242,982.48) | (134,242,982.48) |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | | | 499,551,942.00 | - | 499,551,942.00 |
| 15 | Зарласан ногдол ашиг | | | | - | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | - |
| **17** | **2021 оны 12-р сары 31-ний үлдэгдэл** | 111,595,600.00 | 1,349,166,957.59 | 972,145,473.00 | (95,310,678.78) | 2,337,597,351.81 |



ЦЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР 01

Хүснэгт 1. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны Төлөвлөгөө | 2021 оны Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт** | | | | | | |
| 2 | **Нийт орлого** | м/төг | **119,133.1** | **143,348.2** | **148,311.1** | **(4,962.9)** | **96.6** |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | м/төг | 119,133.1 | 143,348.2 | 148,311.1 | **(4,962.9)** | **96.6** |
| 3 | **Нийт зардал** | м/төг | **232,575.5** | **143,348.2** | **282,399.5** | **(139,051.3)** | **50.7** |
| | Үүнээс: | м/төг | | | | | |
| | а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | 21,661.5 | | | | |
| | б) Ерөнхий ба удирдлагын зардал | **м/төг** | 210,914.0 | 143,348.2 | 282,399.5 | **(139,051.3)** | |
| | в) Хөрөнгө оруулалт их засвар | м/төг | | | | | |
| 4 | **Цэвэр ашиг, алдагдал** | м/төг | **(113,442.4)** | **-** | **(134,242.9)** | **(134,242.9)** | |

үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн орлогын тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн орлогын тайлангийн нийт зардлын 232,575.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,325.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1,860.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Тус байгууллага нь "Байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл, аюулгүй, таатай орчин бүрдүүлэх замаар иргэдийн нийтлэг эрх ашгийг хангах" гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэр усны хангамжийн эх үүсвэр,
- түүний шугам сүлжээнд хяналт тавих, найдвартай ажиллагаа, тогтвортой байдлыг хангах
- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ногоон байгууламжинд хийгдэх үйлчилгээ, сэргээн засварлалт хийх
- Хог хаягдлын төсөл, хөтөлбөр, хог тээвэрлэлт, цуглуулалт, цас мөсний цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах

Улсын бүртгэлийн гэрчилгээнд

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ыг Дархан Уул аймгийн ИТХ-ын 2012 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит



ДУГААР 01

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Орхон сумын Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын */цаашид Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын гэх/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн татварын тайлантай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Т.Эрдэнэтуяа нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Дотоод хяналт

ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс



ЦЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР 01

хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тус газрын санхүүгийн тайлангууд нь НББОУС-ын зөвлөхөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 30.4 | 1,048.7 | 1,018.3 |
| Авлага | 1,662.2 | 7,620.6 | 5,958.4 |
| Бараа материал | 34,044.2 | 34,810.0 | 765.8 |
| Үндсэн хөрөнгө | 1,874,548.6 | 2,235,316.3 | 360,767.7 |
| Биет бус хөрөнгө | 63,867.2 | 63,742.2 | (125.0) |
| **Нийт хөрөнгө** | **1,974,152.6** | **2,342,537.8** | **368,385.2** |
| Өр төлбөр | 1,864.2 | 4,940.4 | 3,076.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,349,167.0 | 1,349,167.0 | 0 |
| Эздийн өмч | 111,595.6 | 111,595.6 | 0 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 472,593.5 | 972,145.5 | 499,552.0 |
| Хуримтлагдсан ашиг | 38,932.3 | (95,310.6) | (134,243.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,974,152.6** | **2,342,537.8** | **368,385.2** |



ЭЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР 01

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,018.3 мянган төгрөгөөр өсөхөд 142,148.2 мянган төгрөгийн орлого орж, 141,129.9 мянган төгрөгийн зардал гарсан нь нөлөөлсөн байна.

Авлагын үлдэгдэл 5,958.4 мянган төгрөгөөр өсөхөд нь байгууллагаас авах авлага голлон шалтгаалсан байна. Нийт авлагын үлдэгдэлд аж ахуй нэгж байгууллагуудаас авах авлага 7,620.6 мянган төгрөг буюу 100 хувийг эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд 2021 онд үүссэн Дархан Ус Суваг ХК 3,277.6 мянган төгрөгийн, Орхондэлгэр ХХК 3,895.0 мянган төгрөгийн зэрэг авлагууд тусгагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 765.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 38,827.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 38,061.7 мянган төгрөгийн материал зарцуулсан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 486,387.9 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор 395,856.8 мянган төгрөгийн Өргөх станц, гүний худаг, цэвэр усны шугам, Дархан-Уул аймаг Орхон сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 67,807.2 мянган төгрөгийн Орхон сумын Баян-Өлзийт багийн хогийн цэгийн хашаа, Цэвэр усны эх үүсвэрийн байгууламжийн хашаа, үйлдвэрийн урд талын амралтын талбай, Орхон сумын иргэдийн хандивын бий болсон Орхон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 28 дугаар тогтоолоор 35,888.0 мянган төгрөгийн Орхон сумын зам дагуу, тоглоомийн талбайн хогийн сав, Саравч, турник, 12 жил, ногоочны хөшөө, Морьтой хөшөө, цагтай хөшөөг үнэ төлбөргүйгээр орлогод бүртгэн, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор үлдэх өртөггүй 13,000.0 мянган төгрөгийн Киа пронтер маркийн бага оврын ачааны автомашин акталж данснаас хассан, мөн 164,0 мянган төгрөгийн орцны гэрлийг үндсэн хөрөнгөөс бараа материалын дансруу шилжүүлсэн нь шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,076.2 мянган төгрөгөөр өссөн нь татвар, НДШ-ийн өглөг 2,219.6 мянган төгрөг, татварын өр 775.9 мянган төгрөг, богино хугацаат өр 120.0 нэмэгдэж, дансны өглөг 39.3 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалсан байна.

Нийт өглөгийн 63.5 хувийг буюу 3,139.1 мянган төгрөгийг НДШ-ийн өглөг, 34.0 хувийг буюу 1,681.2 мянган төгрөгийг татварын өр эзэлж байна.

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 972,145.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 499,552.0 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өргөх станц, гүний худаг, цэвэр усны шугам, Орхон сумын Иргэдийн



ДУГААР 01

хандиваар бий болсон хөрөнгө Орхон сумын зам дагуу, тоглоомийн талбайн хогийн сав, Саравч, турник, 12 жил, ногоочны хөшөө, Морьтой хөшөө, цагтай хөшөөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлзийт багийн хогийн цэгийн хашаа, Цэвэр усны эх үүсвэрийн байгууламжийн хашаа, үйлдвэрийн урд талын амралтын талбай нийлүүлэгдсэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 134,243.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 95,310.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал нөлөөлсөн байна.

Тайлант онд 134,243.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь үндсэн хөрөнгийн элэгдэл өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### 4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сумын Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөгөөр 2021 оны нийт орлогыг 143,348.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 143,348.2 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 148,311.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 282,399.5 мянган төгрөгийн зардал гарган, 134,243.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 148,311.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 4,962.9 мянган төгрөг буюу 0,4 хувиар өссөн нь хэрэглэгч нар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 282,399.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 139,051.3 мянган төгрөг буюу 50.7 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.



ДУГААР 01

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг ил тод байршуулсан байна.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 249.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 2,589.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс акт 100 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /Мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 249.3 | 2 | 249.3 | | | |
| Зөвлөмж | 3 | 2,589.4 | 3 | 2,589.4 | | | |
| Нийт дүн | 5 | 2,838.7 | 5 | 2,838.7 | | | |

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг “0” үлдэгдэлтэй болсон 361,826.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 16 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь НББОУС-ын Үндсэн хөрөнгө 16-ын 34-д “*... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс ихээхэн ялгаатай бол дахин үнэлээг зайлшгүй хийнэ.*” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглахаар бол дахин үнэлэх эсвэл акталж устгах тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 55,918.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 40,808.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,109.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 8.1 Залруулсан алдаа



ЦЭЗБ-АУДИТ ХХК
ДУГААР 01

- Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу хуваарилж 40,808.9 мянган төгрөгийг удирдлагын зардлаар тайлагнасныг залруулав.

### 8.2 Зөвлөмж

**Илрүүлэлт**: Татварын тайланд 15,109.8 мянган төгрөгийн орлого дутуу тайлагнасан байна.

**Өгсөн зөвлөмж**: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.*" гэсэн заалттай нийцэхгүй байна. 2022 онд тухай бүр цахим баримтыг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын | 2 | 55,918.7 | 1 | 40,808.9 | | | | | 1 | 15,109.8 |



ЦЭСБ-АУДИТ ХХК
ДУГААР 01